

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар




ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙГАА НЬ ХЭРЭГЖИЛТЭНД НӨЛӨӨЛЖ БАЙНА.**

АУДИТЫН КОД: ХЭА-2021/122-ШТА-ГА

“ОРОН НУТГИЙН ТӨСӨВ БОЛОН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН
САНГААС 2020 ОНД САНХҮҮЖСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР АШИГ”
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сум 2021 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: erdenebaatararch@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхтүвшин

Утас: 92116764 Цахим хаяг: enkhtuvshints@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ АЖЛЫГ ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.	8
А.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлыг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөхгүй байна.....	8
А.2 Шинээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг техникийн нөхцөлтэй байх шаардлага хэрэгжихгүй байна.....	9
А.3 Их засварыг төлөвлөхдөө холбогдох шаардлагыг баримтлахгүй байна.	10
БҮЛЭГ 2. ЦАХИМ СИСТЕМ (TENDER.GOV.MN)-Д НИЙТ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 9.7%-ИЙГ БҮРТГЭЭГҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТЕНДЕРИЙН 10.6%-ИЙН ҮР ДҮНГ НИЙТЛЭЭГҮЙ БАЙГАА НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЧАДААГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.....	11
Б.1 Үнэлгээний хороог байгуулах, тендер зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлахгүй байна.....	11
Б.2 Цахим системд бүртгэгдсэн тендерийн техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, зураг төслийн баталгаажуулалт хангалтгүй байна.	14
Б.3 Зохион байгуулагдсан тендерийн 10.6%-ийн үр дүнг цахим системд мэдээлээгүй байна.	15
Б.4 Худалдан авах ажиллагааг цахим системээр бүрэн зохион байгуулж чадаагүй байна.....	16
БҮЛЭГ 3. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНД ХЭРЭГЖСЭН 200 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 87.0%-ИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙНА.	16
В.1 Захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг үнэн зөв баталгаажуулан санхүүжилтийг олгож, нийт байгуулсан гэрээний 49.5%-ийг дүгнэжээ.	17
В.2 Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хэрэгжилт 97.0%-тай байна.....	22
В.3 Зөвлөх үйлчилгээ авах гэрээний хэрэгжих хугацаа тодорхойгүйгээс хэрэгжилт 20.0%-тай байна.....	22
БҮЛЭГ 4. ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨГӨӨР ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА. 23	
Г.1 Сумдын ИТХ, ЗДТГ-аас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.	23
Г.2 Цар тахлын нөхцөл байдлаас хамаарч сумдад хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.....	24
Г.3 Хөрөнгө оруулалтын тайланг гаргаж хэлэлцүүлээгүй байна.....	24
Г.4 Хөрөнгийг бүртгэх ажил сумдад хийгдсэн байна.....	25
Холбогдох байгууллагын санал:	26
Саналд өгсөн тайлбар:	26
ДҮГНЭЛТ: 27	
ЗӨВЛӨМЖ:	28

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ТШОЖ	Тендер шалгаруулалтын онцгой журам
ОНОХААЖ	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Төрийн бус байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
АБТӨЯХАТ	Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ХХААХҮ	Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэр
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХОХБТ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Нийт хөрөнгө оруулалтад ОНХО болон ОНХС-ийн эзлэх хувь	8
Дүрслэл 2	Төлөвлөлтийн шаардлага хангасан талаарх судалгаа	10

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нийт батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээлэл	8
Хүснэгт 2	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан мэдээлэл	11
Хүснэгт 3	Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан талаар	14
Хүснэгт 4	Төсөл, арга хэмжээний гэрээний мэдээлэл	17
Хүснэгт 5	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа	18
Хүснэгт 6	Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн судалгаа	18
Хүснэгт 7	Зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл	22

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Сангийн яамны цахим санд ОНХС-ийн мэдээлэл авах хэсэг	9
Зураг 2	Баталгаажаагүй зураг төсвийн зургууд	15

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ХАА-ны цахим системд бүртгэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд	30
Хавсралт 2	Цахим тендерт урилга нийтлэгдээгүй төсөл, арга хэмжээ	31
Хавсралт 3	Худалдан авах ажиллагааны үр дүнг мэдээлээгүй төсөл, арга хэмжээнүүд	32
Хавсралт 4	Захиалагчийн хяналтын баримтгүй төсөл, арга хэмжээнүүд	33
Хавсралт 5	Орон нутгийн өмчид бүртгээгүй төсөл, арга хэмжээнүүд	34

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/28 тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2021 оны аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийлээ.
Аудитын зорилт	“Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас 2020 онд санхүүжсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, зарцуулалт, үр дүн, үр ашиг”-т аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ➤ Хөрөнгө оруулалт, ОНХС-ын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх, ➤ Худалдан авах ажиллагааг ил тод, үр ашигтай зохион байгуулсан эсэх, ➤ Төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх, ➤ Хөрөнгө оруулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулсан эсэх,
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар 2020 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг хамруулан аудит хийв.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан 2021 оны А/28 дугаар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудаас асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж,

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэбилэг ахлан, аудитор Ц.Энхтүвшин хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс эхлүүлж, талбарын ажлыг 2020 оны 05 дугаар сарын 12-оос гүйцэтгэж, тайлагналын үе шатыг 2020 оны 06 дугаар сарын 14-өөс эхлүүлж, тайлан, судалгааг Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлнэ.

**Хүндрэл
бэрхшээл**

.....

**АУДИТЫН ДҮН: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ
БАЙГАА НЬ ХЭРЭГЖИЛТЭНД НӨЛӨӨЛЖ БАЙНА.**

Ерөнхий мэдээлэл

Аймгийн 2020 оны 09 дүгээр сард бүх сумд болон аймгийн төсвийг тодотгохдоо 10720,0 төсөвт өртөгтэй 9166,7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 237 төсөл, арга хэмжээ болгон нэмэгдүүлэн баталсан байна.

Тодотгосон төсөвт ОНХНС-аас Хэнтий аймагт шилжүүлэх орлогын шилжүүлгийг анх 7654,3 сая төгрөгөөр баталсан боловч тодотголоор 7273,8 сая төгрөг болгон бууруулж, гүйцэтгэлээр 7240,5 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын тодотгосон төсвөөр орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн нийт санхүүжилтийг 6010,0 сая төгрөг байхаар баталсан ба сумдын ИТХ-аар сумын хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг 556,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Үүнээс 1453,5 сая төгрөгийг хөрөнгө оруулалтаар, 7713.2 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажилд баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 41 төсөл, арга хэмжээнд 4701,5 сая төгрөг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийтдээ 140 төсөл, арга хэмжээг 3011,5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Жилийн эцсийн гүйцэтгэлээр аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтаар нийт 210 гэрээний санхүүжилтэд 7538,0 сая төгрөг зарцуулснаас орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 53 төсөл, арга хэмжээнд 1251,5 сая төгрөг, ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 157 төсөл, арга хэмжээг 6702,3 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжих 506,8 сая төгрөгийн 26 төсөл, арга хэмжээний батлагдсан санхүүжилт дутуу ирснээс хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 1. ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ АЖЛЫГ ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ТӨЛӨВЛӨЖ БАЙНА.

А.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлыг дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөхгүй байна.

Хэнтий аймаг төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын зардлыг 2020 оны төсвийн төсөлд тусган хуулийн дагуу 2019 оны 12 сард батлахдаа 10424,7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8826,8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 199 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Улмаар 2020 оны 09 дүгээр сард бүх сумд болон аймгийн төсвийг тодотгохдоо 10720,0 төсөвт өртөгтэй 9166,7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 237 төсөл, арга хэмжээ болгон нэмэгдүүлэн баталсан байна.


д/д	Нийт төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
Анх батлагдсан	199	10424,7	8826,8
Тодотгосон	237	10720,0	9166,7
Өөрчлөлт (+/-)	+38	+295,3	+339,9

Хүснэгт 1

Аймгийн ИТХ-ын 2020 оны төсвийн тодотголоор орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн нийт санхүүжилтийг 6010,0 сая төгрөг байхаар баталсан ба сумдын ИТХ-аар сумын хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийг 556,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Үүнээс орон нутгийн төсөв 145,0 сая төгрөгийг Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Хэрлэн, Бор-Өндөр сумд, 1308,5 сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтад баталж нийт 56 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аас баталжээ.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажилд иргэдээс санал авсан байдлыг Сангийн яамны цахим санд оруулсан мэдээлэл болон аймаг, сумдаас цахимаар ирүүлсэн мэдээллээс үзэхэд нийтдээ 18 сум, 4 тосгон бүгд иргэдээс авсан санал, төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн байдал, хэрэгжилт, санхүүжилт, баталсан тогтоол зэргийг сайтад байршуулсан байна.



Дүрслэл 1

Аудитыг цахимаар хийж байгаагаар холбоотой бүх материалыг цахимаар авч байгаа бөгөөд энэ аудитад Биндэр, Дэлгэрхаан, Мөрөн сум болон аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой баримт аудитад хамруулсангүй.

(Аудитад шаардагдах материалыг хугацаанд нь ирүүлээгүй аймгийн ЗДТГ-ын холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв)

Дархан, Батноров, Баян-Овоо, Хэрлэн, Бор-Өндөр сумд, Бэрх, Өлзийт тосгодод орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээг аймаг, сумын дунд хугацааны бодлогын баримт бичигт үндэслэн төлөвлөсөн бол бусад сумдад дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн талаар баримт аудитад хамрагдсангүй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх ажлуудыг аймаг, сумын ИТХ-аар бүгд батлагдсан бөгөөд батлагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Зураг 1


А.2 Шинээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг техникийн нөхцөлтэй байх шаардлага хэрэгжихгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжүүлсэн газрын болон техникийн зөвшөөрөл авах шаардлагатай нийт 63 төсөл арга хэмжээнээс давхардсан тоогоор 2 ажил газрын зөвшөөрөлтэй, 6 ажил ЦЭХ-ний зөвшөөрөлтэй, 1 ажил дулааны зөвшөөрөлтэй, 1 ажил цэвэр, бохир усны зөвшөөрөлтэй байна.

Харин бусад 3908.7 сая төгрөгийн 55 ажлыг хэрэгжүүлэхдээ газрын болон техникийн нөхцөлийн зөвшөөрөл авсан баримт аудитад хамрагдсангүй.

Шинээр хэрэгжүүлэх 1095.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ зураг төсөлтэй, 1416.4 сая төгрөгийн 20 төсөл, арга хэмжээ 2516.8 сая төгрөгийн хяналтын төсөвтэй хэрэгжсэн байна.


Нийтдээ 4831.0 сая төгрөгийн 100 төсөл, арга хэмжээний зураг төсөл, 4509.7 сая төгрөгийн 90 төсөл, арга хэмжээний хяналтын төсөв аудитад хамрагдсангүй.



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 785.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ улсын магадлалаар зураг, төсөл нь орж батлагдсан байна.

Бусад 5141.0 сая төгрөгийн 108 төсөл, арга хэмжээний улсын магадлалд орсон баримт байхгүй байна.

Энэ нь орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган баталсан төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам-ын 7.2¹-т заасан шаардлагыг хангаагүй байна.



Дүрслэл 2

Шинээр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын 3703.2 сая төгрөгийн 35 ажил хэрэгжиж дууссаны дараах ашиглалтын зардал болох урсгал засвар, орон тоо болон төсөвт үүсэх ачааллыг тооцоогүй, санхүүжүүлэх эх үүсвэрийг тодорхойлоогүй байна.

A.3 Их засварыг төлөвлөхдөө холбогдох шаардлагыг баримтлахгүй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын ажлыг хэрэгжүүлэхдээ тухайн төсөл, арга хэмжээний ашиглалтын норм, элэгдлийг тооцсон баримтгүй, засвар үйлчилгээ шаардлагатай талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, шаардлагатай төсвийн тооцооллыг урьдчилан гаргадаггүйгээс хийгдсэн их засвар нь батлагдсан төсөвт багтаадгаас иж бүрэн хийгддэггүй, үр дүн багатай ажил болж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт болон хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд их засвар хийгдэх 500,3 сая төгрөгийн 13 ажлын ашиглалтын хугацаа тооцох шаардлагагүй бол бусад 716.5 сая төгрөгийн 27 төсөл, арга хэмжээний

¹ 7.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй. Үүнд:

7.2.1. эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

7.2.2. барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

ашиглалтын хугацааны элэгдлийг тооцоогүй, түүнд гаргасан дүгнэлт байхгүй байна.

Их засвар хийгдсэн 226.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ зураг, төсөлтэй, 478.9 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ 524.0 сая төгрөгийн хяналтын төсөвтэй хэрэгжжээ.

Нийтдээ 990.8 сая төгрөгийн 36 ажил зураг төсөлгүй, 737.9 сая төгрөгийн 30 их засварын ажил хяналтын төсөвгүй хэрэгжжээ.

Их засвар хийгдэх нийт 1216.8 сая төгрөгийн 40 төсөл, арга хэмжээний зураг төсөл, хяналтын төсөв магадлалаар орж батлагдаагүй хэрэгжсэн байна.

Энэ нь орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хийхдээ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам-ын 7.3²-т заасан шаардлагыг баримтлахгүй байна.

БҮЛЭГ 2. ЦАХИМ СИСТЕМ (TENDER.GOV.MN)-Д НИЙТ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 9.7%-ИЙГ БҮРТГЭЭГҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ТЕНДЕРИЙН 10.6%-ИЙН ҮР ДҮНГ НИЙТЛЭЭГҮЙ БАЙГАА НЬ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЧАДААГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

Б.1 Үнэлгээний хороог байгуулах, тендер зарлахдаа худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлахгүй байна.

Аймаг, сумын хэмжээнд 2020 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 181, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 56, нийт 237 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах төлөвлөгөө батлагдсанаас худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 214 бараа, ажил, үйлчилгээ бүртгэгдэж, 23 бараа, ажил, үйлчилгээ бүртгэгдээгүй байна. Бүртгэгдсэн нийт бараа, ажил, үйлчилгээний 24 нь НТШ-аар, 122 нь ТШОЖ, 7 нь ЗҮГСШЖ, 2 нь ОНОХААЖ-ийн дагуу зохион байгуулагдахаар, 59 нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”**-ийн дагуу шууд худалдан авалт хийхээр төлөвлөгдсөн байна.

	Төсөв захирагчаар	Цахим системд бүртгэгдсэн эсэх		Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам				
		тийм	үгүй	НТШЖ	ТШОЖ	ЗҮГСШЖ	ОНОХААЖ	ШХА
Нийт худалдан авах ажиллагаа	237	214	23	24	122	7	2	59
Орон нутгийн хөгжлийн сан	181	166	15	22	91	6	2	45

² 7.3. Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг тавина:

7.3.1. шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх;

7.3.3. холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

7.3.4. тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалд үндэслэсэн байх.

Орон нутгийн хөрөнгө оруулалт	56	48	8	2	31	1	0	14
-------------------------------	----	----	---	---	----	---	---	----

Хүснэгт 2

Худалдан авах ажиллагааны цахим системд нийт 232.2 сая.төг-ийн 23 бараа ажил үйлчилгээ бүртгэгдээгүй байгаа нь хуулийн 48.5³-д заасныг зөрчиж, худалдан авах ажиллагаанд оролцогчдын өрсөлдөх тэгш боломжтой байх зарчим алдагдсан байна. (Худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэгдээгүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар гаргае)

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ХАА-г зохион байгуулахдаа нэг ажлыг хэд хэдэн хэсэг болгон төлөвлөж худалдан авах ажиллагаанд тусгасан байгаа нь хуулийн 8.5⁴ заалтыг санаатайгаар зөрчсөн байна гэж үзэхээр байна.

Тухайлбал: Баян-Адарга сумын Аврах бүлгийн байр засварлахад аймгийн ОНХО-ын зардлаас 10.0 ба 55.0 сая.төг-ийн 2 ажил, аврах бүлгийн байр засварлахад сумын ОНХО-аас 3.0 сая.төг, аймгийн ОНХО-аас 10.0 ба 19.0 сая.төг-ийн 3 ажил, Бэрх тосгоны орон сууцны байрны дундах тоглоомын талбайг араг, арван сая.төг-өөр салгаж 2 ажил, нийтийн эзэмшлийн гудамж талбайд сандал, хогийн сав байршуулах ажлыг 10.0 ба 3.9 сая.төг-өөр салган 2 ажил болгон төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.

Мөн төсөл, арга хэмжээг он дамжуулан санхүүжүүлдэг, аймаг, сумын төсвөөс хувааж санхүүжүүлдэг, төсөл, арга хэмжээний нэрийг өөрчлөн санхүүжүүлдэг зөрчлүүд гарсаар байна.

Тухайлбал: Бор-Өндөр сум "Уурхайчин" цэцэрлэгт хүрээлэн байгуулахад 2019 онд 32.0 сая.төг зарцуулсан бол тохижуулахад 2020 онд 100.0 сая.төг төсөвлөсөн, Дэлгэрхаан сум мал нядалгааны нэгдсэн цэг байгуулахад сумын ОНХС-аас 2020 онд 55.1 сая. төг төсөвлөсөн бол тохижуулахад 2021 онд 29.3 сая.төг төсөвлөн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгажээ.

Мөн Баян-Овоо сумын Хогийн цэгийн хашаажуулалтын ажилд сумын ОНХО-аас 80.0 сая.төг, аймгийн ОНХО-аас 20.0 сая.төг-ийн 2 ажил, Дадал сумын "Тэнхлэг, Баянбулаг голын гүүрийг барьж, замыг засах ажилд сумын ОНХС-аас 27.9 сая.төг, аймгийн ОНХС-аас 60.0 сая.төг-ийн 2 ажил, Жаргалтхаан сумын дүрс ашиглалтын камер авч суурилуулахад сумын ОНХС-аас 10.0 сая.төг, аймгийн ОНХС-аас 35.0 сая.төг-ийн 2 ажил, Хэрлэн сумын 4-р багийн Эрчмийн 60 айлын инженерийн шугам сүлжээг барих ажлын тендер 2019 онд зарлагдаж аймгийн ОНХС-аас 150.0 сая.төг, 2020 онд УТХО-аас 840.0 сая.төг-ийн ажил хийгдсэн боловч аймгийн ОНХС-аас 30.0 сая.төг-ийг нэмж төлөвлөж хэрэгжүүлжээ.

Шууд худалдан авахаас бусад 155 худалдан авах ажиллагаанаас 61 үнэлгээний хорооны талаарх судалгаа ирээгүй байна.

Судалгаа ирүүлсэн 94 худалдан авах ажиллагааны 65-ийн үнэлгээний хороо төлөвлөгөөнд заасан хугацаанаас 2-230 хоногоор хэтрүүлэн байгуулагдсаны дотор Аймгийн Засаг дарга 25, Батноров сумын Засаг дарга 3, Баянмөнх сумын Засаг дарга 1, Баянхутаг сумын Засаг дарга 2, Дархан сумын Засаг дарга 1, Хэрлэн сумын Засаг дарга 5,

³ "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ"

⁴ "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"

Цэнхэрмандал сумын Засаг дарга 1, нийт 38 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог төлөвлөсөн хугацаанаас 1 сараас дээш хугацаагаар хэтрүүлэн байгуулсан нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөн хугацаандаа зохион байгуулагдахгүй байх нэг нөхцөл болж байна.

Мөн 13 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог төлөвлөсөн хугацаанаас 10-аас дээш хоногийн өмнө байгуулагдсан нь тендерийн үнэлгээнд хөндлөнгийн хүчин зүйлс нөлөөлөх, үгсэн хуйвалдах, ашиг сонирхлын зөрчил үүсэх зэрэг сөрөг үзэгдэл бий болох магадлалтай байх тул цаашид анхаарах нь зүйтэй.

Тендер сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хороог байгуулахдаа хуулийн 47.4. **“Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна”** гэсэн заалтыг хангаж ажиллахгүй байна.

Түүвэрт хамрагдсан 94 үнэлгээний хорооны 27-д нь тухайн шатны ЗДТГ-ын төлөөлөл, 57-д нь мэргэжлийн холбоодын төлөөлөл, 78-д нь ИТХ-аас томилсон иргэн, 56-д нь хувийн хэвшлийн болон ТББ-ын төлөөлөл байхгүй байгаа нь худалдан авах ажиллагааны ил тод байх зарчим алдагдсан байна.

Нийт 155 худалдан авах ажиллагаанаас 132 тендер цахимаар зарлагдаж, 23 тендер зарлагдаагүй байна. Цахимаар зарлагдсан 132 тендерийн 88 нь төлөвлөгдсөн хугацаанаасаа 10-аас дээш хоногоор хэтэрч зарлагдсан байна. 48 тендер оролцогчгүй, эсхүл шаардлагад нийцсэн оролцогч байхгүй шалтгаанаар 2-10 удаа зарлагдаж байжээ. Мөн 4 тендерийг хуульд заасан үндэслэлээр 2-3 багц болгох, 44 тендерт орон нутгийн давуу эрх тооцохоор тендерийн урилгад тусгасан байна.

	Зохион байгуулагдсан ХАА		Тендерийн урилга нийтлэгдсэн эсэх		Хугацаа хэтэрч зарласан ХАА	Зарлагдсан төсөв өртөг /сая.төг/	Тендер зарласан удаа		
	Тоо	Багц	тийм	үгүй			1	2	3-с дээш
Нийт худалдан авах ажиллагаа	155	4	132	23	88	9359.5	84	28	20
Орон нутгийн хөгжлийн сан	121	4	102	19	71	8088.4	63	24	15
Орон нутгийн хөрөнгө оруулалт	34	0	30	4	17	1271.1	21	4	5

Хүснэгт 3

Цахим тендер зарлагдаагүй зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь аймгийн ОНӨГ 4, Баянмөнх сумын ЗДТГ 1, Баян-Овоо сумын ЗДТГ 2, Баянхутаг сумын ЗДТГ 3, Биндэр сумын ЗДТГ 2, Дархан сумын ЗДТГ 2, Норовлин сумын ЗДТГ 3, Өмнөдэлгэр сумын

ЗДТГ 4, Цэнхэрмандал сумын ЗДТГ 2, нийт 23 төсөл, арга хэмжээ байна. (цахим системд тендерийн урилга нийтлэгдээгүй төсөл, арга хэмжээг хавсаргав)

Б.2 Цахим системд бүртгэгдсэн тендерийн техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, зураг төслийн баталгаажуулалт хангалтгүй байна.

Барилга байгууламж шинээр барих, их засвар, тохижилт хийх нийт 86 ажлын гүйцэтгэгч, Тоног төхөөрөмж, автомашин худалдан авах 40 ажлын нийлүүлэгч, Зураг төсөл боловсруулах 6 ажлын гүйцэтгэгчийн шалгаруулах тендер зарлагдсан.

Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа жишиг баримт бичгийг загвар болгон ашиглаж байгаа боловч захиалагч баталгаажуулаагүй тендерийн баримт бичиг, зураг төслөөр тендер зарлагдсан тохиолдол цөөнгүй байна.

Жишээлбэл Баян-Овоо сумын “Хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнгийн тоглоом нэмэгдүүлэх, тохижуулах” (ХЭАБОСЗДТГ/202012019), Бор-Өндөр сумын “ЕБС-д хүүхдийн автобус авах” (ХЭАБӨСЗДТГ/202001002)-ын тендерийн баримт бичиг, Батширээт сумын “Төв гудамжны 400м бетон зам”, Норовлин сумын “Сурагчдын хөдөлмөр амралтын ЭКО зуслангийн байр”-ны зураг төслүүд баталгаажгаагүй байна.

Цахим системд зарлагдсан 85 тендер (3 багц)-т оролцох хүсэлт гаргасан 120 оролцогчийн нэр, санал болгосон үнийн дүн, шалгарсан ба шалгараагүй шалтгааныг цахим системд бүртгэсэн байна. Төсөвт өртгөөс илүүгүй үнийн санал ирүүлсэн 82 тендерээс 194.2 сая.төг-ийн арвилан хэмнэлт гарсан байна.

Галшар сумын ЗДТГ "Нийтийн халуун ус барих" ажилд "Хасумегаватт" ХХК 0.8 сая.төг, аймгийн ОНӨГ "Камер суурилуулах /Жаргалтхаан/" ажилд "Төгсхурц консалтинг" ХХК 9.6 сая.төг, "Тэнхлэг, Баянбулаг голын модон гүүр шинээр байгуулах (Дадал)" ажилд "Цагаанбулаг андууд" ХХК 17.9 сая.төг, нийт 28.3 сая.төг-ийн илүү үнийн санал ирүүлснийг шалгаруулсан байна.

Энэхүү аймгийн ОНХС-аас зарласан тендерт төсөвт өртгөөс илүү үнийн дүн ирүүлж шалгарсан ажлын төсвийн зөрүүг тухайн сумын ОНХС-аас санхүүжүүлсэн байна.

Шалгарсан 85 оролцогчоос 33 оролцогчтой байгуулсан гэрээний огноо, үнийн дүнг тодорхой зарлажээ. Харин 34 оролцогчтой гэрээ байгуулсан огноо, үнийн дүнг зарлаагүй байгаа нь худалдан авах ажиллагаа ил тод байх зарчимтай нийцэхгүй байна.

Б.4 Худалдан авах ажиллагааг цахим системээр бүрэн зохион байгуулж чадаагүй байна.

Нийт 10.0 сая.төг-өөс дээш төсөвт өртөг бүхий 145 бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа төлөвлөгдсөнөөс 111 тендер бүрэн цахимаар зохион байгуулагдаж, мэдээллийг цахим системд бүртгэсэн байна.

Шалгарсан 85, багцад шалгарсан 3 нийт 88 оролцогчид гэрээ байгуулах эрх олгосон албан бичгийг хүрүүлснээс 13 оролцогчид төлөвлөсөн хугацаанд, 47 оролцогчдод төлөвлөсөн хугацаанаас 2-187 хоногоор хэтэрч олгосон нь тендерийг төлөвлөсөн хугацаанд зарладаггүй, оролцогчгүй улмаас дахин зарлах зэрэг шалтгаантай холбоотой байна. Эдгээр тендерүүд төлөвлөсөн хугацаанаас 4-119 хоногийн дараа зарлагдаж, 22 тендер 2-6 удаа зарлагдсан байна. Харин 28 шалгарсан оролцогчид хүргүүлсэн "гэрээ байгуулах эрх олгосон" албан бичгийг баримтжуулж чадаагүй болно.

Шалгарсан 85 оролцогчоос 55-тай нь гэрээ байгуулахдаа тендер хүчинтэй байх хугацаанд байгуулж чадаагүй байгаа нь гэрээ байгуулах эрхийг төлөвлөсөн хугацаанд олгож чадаагүйтэй холбоотой юм.

Бор-Өндөр сумын "Эмнэлгийн рентген аппарат", Норовлин сумын "Цамхагт гэрэлтүүлэг", Хэрлэн сумын "5 найман айлын фасад", аймгийн "Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Баян-Адарга/" тендерүүдэд оролцогчид Сангийн яаманд, Дэлгэрхаан сумын "Мал нядалгааны нэгдсэн цэгтэй болох" тендерт оролцогч АТГ-т худалдан авах ажиллагааны талаар гомдол гаргажээ. Сангийн яаманд гаргасан гомдлын 50% нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн байна.

Харин АТГ-т гаргасан гомдлын шийдвэрийн талаар сумын ЗДТГ-т албан ёсоор мэдэгдээгүй байна.

БҮЛЭГ 3. АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2020 ОНД ХЭРЭГЖСЭН 200 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 87.0%-ИЙН ҮР ДҮНТЭЙ БАЙНА.

В.1 Захиалагч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг үнэн зөв баталгаажуулан санхүүжилтийг олгож, нийт байгуулсан гэрээний 49.5%-ийг дүгнэжээ.

Аймгийн хэмжээнд 2020 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт 242 ажлын 200 ажилд гэрээ байгуулагдсан байна.

	Гэрээ байгуулсан эсэх			Байгуулсан гэрээ					Ажлын гүйцэтгэл		
	Тийм	Үгүй	Төсөл	Гэрээний дүн /сая.төг/	ББ	ИЗ	ТТ	ЗТ	100 %	0%< <100 %	0%
Нийт худалдан авах ажиллагаа	200	32	10	9665,0	112	35	48	5	174	22	4
Орон нутгийн хөгжлийн сан	149	27	10	8214,5	95	20	30	4	130	18	1
Орон нутгийн хөрөнгө оруулалт	51	5	0	1450,5	17	15	18	1	44	4	3

Хүснэгт 4

Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд нийт 8273.2 сая.төг зарцуулагдсан ба ажлыг бүрэн дуусгахад 1962,1 сая.төг шаардлагатай байна.

	Нийт санхүүжилт		Гэрээгээр		Журмаар		Төсөлд дэмжлэг		Гэрээгүй	
	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)
Нийт худалдан авах ажиллагаа	209	8273.2	197	8137.9	4	431.7	10	75.3	2	60.0
Орон нутгийн хөгжлийн сан	158	6899.3	147	6810.8	2	399.6	10	75.3	1	10.0
Орон нутгийн хөрөнгө оруулалт	51	1373.9	50	1323.9	20	32.1	0	0	1	50.0

Хүснэгт 5

“Орон нутгийн хөгжлийн сан”-ийн журамд заасны дагуу мал эмнэлгийн тарилгын зардал 388.6 сая.төг, “Хэнтий Ус” ХХК-ийн алдагдалд 11.0 сая.төг, нийт 399.6 сая.төг-ийг, Замын сангийн хөрөнгөнөөс Хэрлэн голын гүүрэн дэх хяналтын постын санхүүжилтэд 26.5 сая.төг, “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 22.1.4⁵-т заасны дагуу “Албан журмын даатгагчдын холбоо”-нд 2019 оны АТБӨЯХАТ-н орлогын 10% гүйцэтгэлд 5.6 сая.төг-ийг шилжүүлсэн байна.

⁵ 22.1.4.автоматээр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь;

Жаргалтхаан сумын ОНХС-гаас “Сумын төвд дүрс ашиглалтын хяналтын камер худалдан авах” ажилд зарцуулсан 10.0 сая.төг-ийг аймгийн ОНХС-гаас санхүүжүүлэх “Камер суурилуулах /Жаргалтхаан/” ажлын гэрээгээр, аймгийн ОНХО-аас “Тэнхлэг, Баянбулаг голын модон гүүр шинээр байгуулах (Дадал)” ажилд 50.0 сая.төг-ийг Дадал сумын ОНХС-гаас санхүүжүүлэх “Тэнгэлэг гол, Баян голын гүүрний засвар” ажлын гэрээгээр тус тус санхүүжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчтэй байгуулсан 200 ажлын гэрээнээс 2020 онд 6 ажилд санхүүжилт хийгдээгүй байна.

	Нийт санхүүжилт		Санхүүжилт төрлөөр							
	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Гүйцэтгэгчид	Зураг төсөл	Зохиогчийн хяналт	Захиалагчийн хяналт	Банкны баталгаагаар	ЗДТГ-ын дансанд	Алданги	10018 0051410
Нийт худалдан авах ажиллагаа	194	7383.5	6896.5	167.1	25.6	5.5	72.6	220.3	0.1	68.4
Орон нутгийн хөгжлийн сан	144	6214.1	5929.3	151.1	24.4	5.5	0.0	39.0	0.0	64.8
Орон нутгийн хөрөнгө оруулалт	50	1169.4	967.2	16.0	1.1	0.0	72.6	181.3	0.1	3.6

Хүснэгт 6

Ажил гүйцэтгэх 152, багцын 5, нийт 157 барилга байгууламж барих, их засвар хийх ажлаас 7986.6 сая.төг-ийн 128 гэрээ байгуулагджээ. Харин 309.5 сая.төг-ийн төсөвт өртөг бүхий 19 ажилд санхүүжилт хугацаандаа ирээгүй, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаас татгалзсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй, өөр өөр эх үүсвэрээс санхүүжих зэрэг шалтгаанаар гэрээ байгуулагдаагүй байна. Ажлын 43 гэрээнд 102.1 сая.төг-ийн зураг төслийн үнэ, 40 гэрээнд 36.9 сая.төг-ийн зураг төсөл зохиогчийн хяналтын зардал, 47 гэрээнд 80.0 сая.төг-ийн захиалагчийн хяналтын зардал тусгасан байна.

"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төсөл, Хэнтий аймгийн хооронд №200407/01/097 дугаар бүхий "Хамтран ажиллах гэрээ"-ээр 18 суманд 644.0 сая.төг-ийн төсөв өртөг бүхий инженерийн хийцтэй 28 худаг, 17 суманд 255.0 сая.төг-ийн төсөвт өртөг бүхий 17 бог мал угаах ванн шинээр барьж байгуулах ба төсөвт өртгийн 30%-ийг орон нутгаас гаргахаар тусган ХХААХҮ-ийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020/03/10 өдрийн А/65 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах эрхийг Хэнтий аймгийн ХХАА-н газрын даргад олгожээ.

"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслөөс хэрэгжүүлж буй арга хэмжээний 30%-ийн санхүүжилтийг Батноров, Баянмөнх, Биндэр, Дархан, Цэнхэрмандал сумд болон Бэрх тосгоны ОНХС-аас санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны №288 дугаар тушаалаар баталсан **"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл**

ажиллагааны журам”-ын **"Баг, хорооны түвшинд ОНХС-ийн төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангах", "Сум, дүүргийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх"** зүйлүүдийг бүхэлд нь зөрчсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэх 128 гэрээнээс 108 гэрээний хэрэгжилт бүрэн, 19 гэрээний хэрэгжилт дутуу, 1 гэрээ хэрэгжээгүй байна. Өмнөх 2018, 2019 онд эхэлсэн 10 ажлын 7 нь бүрэн дуусаж, 3 нь дуусаагүй байна. Дуусаагүй 3 ажил нь **"Биндэр сумын малын угаалгын ванн, хашаа барих"** ажлууд байгаа бөгөөд 2020 онд санхүүжилт нь хүрэлцээгүй байна. Бор-Өндөр сумын **"35-44 байрны гадна тоглоомын талбай байгуулах"** ажлын тендер шалгаруулалт 6 удаа явагдаж 2020/10/06-нд "Өндөрхаан өргөө" ХХК шалгарч ажлыг 2021/07/01-нд дуусгахаар гэрээ байгуулсан боловч ажил эхлээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.

Аудитын явцад Чингис хотын хэмжээнд хэрэгжиж байгаа 26 ажилтай танилцахад **"6-р цэцэрлэгийн баруун талыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, аюулгүйн бүс бий болгох"** ажлын зүлэгжүүлэлт дутуу, **"1-р багт тоглоомын талбай байгуулах"** ажлын сагсны талбайн нэг самбар байхгүй болсон, **"БАМ-ын байрны дээврийн их засвар (1-р баг)"** ажил хангалтгүй хийгдэж, дээврээс дахин ус гоожсон, **"Нийтийн халуун ус"** ажил дууссан боловч цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй, **"Хэрлэн сумын 1-р багт аялал жуулчлалын гудамж байгуулах ажлын үргэлжлэл /Монголын эзэнт гүрний мини парк"** ажлын санхүүжилт дутмагаас удаашралтай байгаа, **"Усан оргилууруудын засвар /Хэрлэн/"** ажил хийгдсэн боловч ажиллахгүй байгаа зэрэг дутагдал илэрснийг Хэрлэн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Г.Мөнхжаргалд танилцуулж, зөрчлийг арилгах чиглэл өглөө.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 10.7.8-д **"Захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэлийг энэ журмын Хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана"** гэсэн заалтыг удирдлага болгон ОНХО, ОНХС-аас санхүүжүүлж байгаа хөрөнгө оруулалтын нийт ажлын 48.8%-ийг "Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл"-ийг баталгаажуулсан байна.

ОНХО, ОНХС-аас санхүүжүүлж байгаа хөрөнгө оруулалтын нийт ажлын 51.2% буюу аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн эрх шилжсэн 7, сумдын ЗДТГ 48 ажлын "Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл"-ийг баталгаажуулсан баримт байхгүй байна.

Сумдад төсвөөр санхүүжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлийн тайлагналыг нэгтгэх, жил бүрийн аудитаар гарч байгаа зөрчил, дутагдал төдийлөн арилахгүй байгаа шалтгаан нь хариуцсан албан тушаалтан тодорхойгүй байгаагаар холбоотой юм.

ОНХС-ийн үйл ажиллагааг зарим сумдад "сан хариуцсан" нягтлан бодогчдод хариуцуулсан ч үйл ажиллагаатай зарим асуудалд тодорхой тайлбарлаж чадахгүй байх тохиолдол гарч байна.

Иймд Сангийн сайдын 2018 оны №288. "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5⁶-д заасан "сумын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,

⁶ Сангийн сайдын 2018 оны №288. "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 8.5.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2016 оны "Журам шинэчлэн батлах тухай" 415 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төсвийн хөрөнгө

төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан”-г бий болгох, 8.6⁷-д заасан албан тушаалтнуудаар ОНХС-ийн Төрийн сан дах данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад гарын үсэг зуруулж байх нь зүйтэй байна.

Бүрэн дуусан 5708.4 сая.төг-ийн 108 ажилд 2020 оны байдлаар нийт 5053.6 сая.төг-ийн санхүүжилт олгож, 654.8 сая.төг-ийн санхүүжилт дутуу байна. 2020 оноос өмнөх жилүүдэд 4 ажлын 280.6 сая.төг, Дадал сумын "Тэнгэлэг гол, Баян голын гүүрний засвар" ажлын 50.0 сая.төг-ийг аймгийн Замын сангаас, Жаргалтхаан сумын "Камер суурилуулах /Жаргалтхаан/" ажлын 10.0 сая.төг-ийг сумын ОНХС-аас санхүүжүүлсэн байна. Ажил нь дууссан боловч олгогдоогүй 7 ажлын 643.9 сая.төг-ийг 2021 онд санхүүжүүлэхээр аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор шийдвэрлэсэн байна. Харин зураг төсөл зохиогчийн болон захиалагчийн хяналтын 8.0 сая.төг-ийг баримтгүй шалтгаанаар, гэрээний хугацааны алданги тооцож 1.7 сая.төг-ийг, ажлын гүйцэтгэлийг үндэслэн 1.2 сая.төг-ийг олгоогүй байна.

Батноров сумын ОНХС-аас 4.5 сая.төг, Бэрх тосгоны ОНХС-аас 11.4 сая.төг, Баянмөнх сумын ОНХС-аас 11.4 сая.төг, Биндэр сумын ОНХС-аас 11.4 сая.төг, Дархан сумын ОНХС-аас 18.3 сая.төг, Цэнхэрмандал сумын ОНХС-аас 18.3 сая.төг, нийт 75.3 сая.төг-ийг төсөл хэрэгжүүлэх ажилд иргэдээс санал авахгүйгээр зарцуулсан нь "Төсвийн тухай" хууль: 60.3.6."Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ"-д ОНХС-ийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно гэснийг зөрчсөн байна.

Иймд иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээнд ОНХС-аас санхүүжилт олгосон сумдын Засаг дарга нарт дахин зөрчлийг давтахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

Дуусаагүй 2228.7 сая.төг-ийн өртөг бүхийн 19 ажилд 2020 оны байдлаар 1711.8 сая.төгийн санхүүжилт олгогдож, 948.6 сая.төг-ийн санхүүжилт дутуу байна.

Дээрх ажлуудын 3 нь 2019 онд (Биндэр сумын мал угаалгын ванн, хашаа барих 3 ажлын 6.6 сая.төг-ийн санхүүжилтийг одоо болтол төсөв хүрэлцэхгүй олгогдоогүй), 18 нь 2020 онд (ажлын гүйцэтгэлийг үндэслэн 5 ажлын 55.7 сая.төг-ийг олгоогүй), 1 нь 2021 онд дуусахаар гэрээ байгуулсан байна.

Харин Баян-Адарга сумын "Аврах бүлгийн байрны засвар" ажлын гүйцэтгэл 80%-иар баталгаажсан байхад санхүүжилтийг бүрэн, Өмнөдэлгэр сумын "Өмнөдэлгэр сумын Хэнтий, Талын булаг багт гүн өрмийн худаг гаргах" ажлын 14.5 сая.төг-ийн санхүүжилтийг банкны баталгаагаар урьдчилж олгожээ.

Үүнээс 2020 онд дуусах гэрээтэй 7 ажлын 851.7 сая.төг, 2021 онд дуусах гэрээтэй 1 ажлын 48.5 сая.төг, нийт 900.3 сая.төг-ийг 2021 онд санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно.

⁷ 8.6.Энэ журмын 8.5-д заасан санхүүжилтийн эрхийн дагуу ОНХС-ийн Төрийн сан дах данснаас гүйлгээ хийх төлбөрийн хүсэлтийн баримтад аймаг, нийслэлийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч, сум дүүргийн хувьд 1 дүгээр гарын үсгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх шилжүүлсэн албан тушаалтан, 2 дугаар гарын үсгийг Засаг даргын Тамгын газрын ахлах нягтлан бодогч тус тус зурна.

Гэрээний хэрэгжилт бүрэн дууссан 108 ажлаас 70 гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн баримттай, 38 гэрээг дүгнэсэн баримтыг ирүүлээгүй байна. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр 48 ажил гэрээний дуусах хугацааг 1-366 хоногоор хэтрүүлэн ашиглалтад оруулсан байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 11 комисс 2-3 удаа ажиллаж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулан ашиглалтад оруулсан байна. Харин нэг удаа ажиллаж ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан 9 комисс 32 үүрэг даалгавар өгсөн боловч 5 үүрэг даалгавар хэрэгжсэн гэсэн судалгаа ирүүлсэн нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг эргэж биечлэн шалгадаггүй дутагдал байна.

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын *Барилга байгууламжийг ашиглалтад оруулах арга хэмжээний тухай*” 2018 оны А/417 дугаар Захирамжаар байгуулсан бүрэлдэхүүнээр өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа нь Засгийн газрын 2018 оны №317 дугаар тогтоолоор баталсан **"Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"**-ын 3.1.2⁸-т заасныг мөрдөөгүй, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргах хурлын тэмдэглэлд үүрэг, даалгавар өгсөн тухай тэмдэглэгдсэн байгаа нь дээрх дүрмийн 4.8.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллахгүй байгаатай холбоотой байна.

Аймгийн ЗДТГ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 61 төсөл, арга хэмжээ, Хэрлэн сумын ЗДТГ 6 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийлгэх гэрээг ГХБХБ-тай байгуулжээ.

Ажил гүйцэтгэх 128 ажлын гэрээний 47-д нь 80.0 сая төгрөгөөр захиалагчийн хяналт хийлгэхээр тусгасан байна.

	Гэрээ		Хэрэгжилт			Санхүүжилт		
	Төсөл, арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Хяналт шалгалт	Хэдэн удаа	Илэрсэн зөрчил	Артлагсан эсэх	Гүйцэтгэл гаргасан	Олгосон
Нийт худалдан авах ажиллагаа	47	80.0	33	38	19	17	57.8	5.0
Орон нутгийн хөгжлийн сан	36	68.9	25	30	15	14	48.3	5.0
Орон нутгийн хөрөнгө оруулалт	11	11.1	8	8	0	0	9.5	0.0

Захиалагчийн хяналтын гэрээний дагуу 31 ажилд 50.1 сая.төг-ийн хяналтыг хэрэгжүүлсэн байна. 18.5 сая.төг-ийн 2 ажлын захиалагчийн хяналт 2019 онд хийгдсэн. Бүрэн дууссан 6 ажлын 5.0 сая.төг-ийн захиалагчийн хяналтыг баталгаажуулан 5.0 сая.төг-ийн хяналтын зардлыг олгосон байна. Захиалагчийн хяналт хийсэн баримт дутуу ОНХС-ийн 21 ажлын 64.8 сая.төг, ОНХО-ийн 5 ажлын 3.6 сая.төг, нийт 68.4 сая.төг-ийг аймгийн Төрийн сан дахь захиалагчийн хяналтын 100180051410 дансанд төвлөрүүлсэн байна.

⁸ Энэ дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, 2 дахь заалтад заасан бүрэлдэхүүнтэй комиссыг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр хуульд заасан хугацаанд⁸ байгуулж ажиллуулах”

Нийт 11.3 сая.төг-ийн 14 ажлын захиалагчийн хяналт хийсэн баримт ирүүлээгүйн ихэнх нь эрх шилжүүлсэн ажлууд байна. (*Захиалагчийн хяналтын баримтгүй төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсаргав*).

Нийт 45.1 сая.төг-ийн 25 ажлын захиалагчийн хяналтыг баталгаажуулсан баримтгүй, зардлыг олгоогүй байна. Энэ нь аймгийн ГХБХБ-ын газартай хийсэн захиалагчийн хяналтыг төлөөлүүлэн тавих гэрээний хэрэгжилтийг бүрэн хангуулах, гэрээг дүгнэх ажлыг орхигдуулж байгаатай холбоотой юм.

Ажил гүйцэтгэх 128 ажлын гэрээний 42-д нь 37.4 сая.төг-ийн зураг төсөл зохиогчийн хяналт хийлгэхээр тусгасан байна. Үүнээс 20.4 сая.төг-ийн 26 зураг төсөл зохиогчийн хяналтын гэрээг байгуулжээ.

Цэнхэрмандал сумын "ЕБС-ын спорт заалны их засвар", аймгийн "Хэрлэн сумын багуудын гэр хороололд жишиг гудамж бий болгох" ажлын зураг төсөл зохиогчийн 0.4 сая.төг-ийн зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн баримт ирүүлээгүй байна.

Зураг төсөл зохиогчийн хяналтын 24 гэрээний гүйцэтгэлийг хянаж, 18.7 сая.төг-ийн зардлыг бүрэн, 5 гэрээний зураг төсөл зохиогчийн хяналтын ирүүлсэн баримтыг үндэслэн 1.3 сая.төгийн зардлыг дутуу олгосон байна.

В.2 Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний хэрэгжилт 97.0%-тай байна.

Тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх 78 ажлаас 67 ажлын нийт 1455.7 сая төгрөгийн гэрээ байгуулагдаж 11 ажилд гэрээ байгуулагдаагүй байна.

Тоног төхөөрөмж, автомашин нийлүүлэх нийт 1412.8 сая төгрөгийн 65 гэрээ хэрэгжиж, 1333.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 78.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна. Олгогдоогүй байгаа санхүүжилтийн 77.0 сая төгрөгийг 2021 онд олгохоор шийдвэрлэсэн, 0.8 сая төгрөгийг алдангид тооцсон ба 1.1 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгоогүй байна.

Дархан сумын 14.3 сая төгрөгийн "Дизель генератор, дулаан хязгаарлагч", Бор-Өндөр сумын 28.6 сая төгрөгийн "Хот тохижилтын тоног төхөөрөмж" нийлүүлэх гэрээ хэрэгжээгүй ба "Хот тохижилтын тоног төхөөрөмж"-ийн санхүүжилтийг банкны баталгаагаар урьдчилан шилжүүлжээ.

В.3 Зөвлөх үйлчилгээ авах гэрээний хэрэгжих хугацаа тодорхойгүйгээс хэрэгжилт 20.0%-тай байна.

Зураг төсөл боловсруулах 7 ажлаас 5 ажилд нийт 222.8 сая.төг-ийн гэрээ байгуулагдаж, 2 ажилд гэрээ байгуулагдаагүй байна.

Зураг төсөл боловсруулах 10.0 сая.төг-ийн 1 гэрээ бүрэн хэрэгжсэн ба 2020 оны 5 сард байгуулсан 3 гэрээний хэрэгжилт дутуу ба 97.9 сая.төг олгогдож, 85.4 сая.төг-ийг 2021 онд олгохоор шийдвэрлэсэн байна. Харин "Цагдан хорих байрны зураг төсөл"-ийг боловсруулах ажлын гэрээг 2020/12/24 нд байгуулж, банкны баталгаагаар зураг төслийн үнэ 29.5 сая.төг-ийг шилжүүлсэн байна.

Зураг төсөл боловсруулах ажлын гэрээнд хэрэгжих хугацаа зааж өгөөгүйгээс ажил удааширч байгаа тул Зураг төсөл боловсруулах ажлын хугацааг тодорхой болгож, гэрээнд тусгаж байх нь зүйтэй байна.

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжилт			Зураг төсөл боловсруулалтын бэлтгэл ажил		
		Дууссан	Дуусаагүй	Хэрэгжээгүй	Архитектур төлөвлөтийн даалгавар, ГХБХБГ-БХБ	Зураг төслийн даалгавар, ЗАХИАЛАГЧ	Загвар зураг. Ерөнхий архитектур
	НИЙТ ДҮН	1	3	1	4	3	2
	Орон нутгийн хөгжлийн сан	1	3	0	3	3	2
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	0	0	1	1	0	0
Нэг: Орон нутгийн хөгжлийн сан							
1	Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэлийн ажлын зураг төсөл		50%		Шаардлагагүй	2020-01-19	Шаардлагагүй
2	Хан Хэнтий чуулгын барилгын шаардлагатай зураг төсөл		55%				
3	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байрны зураг төсөл	100%					
4	Дулааны станцын гадна холбоо дохиоллын ажлын зураг төсөл				Шаардлагагүй	2020-10-05	Шаардлагагүй
5	Аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэгийн зураг төсөл		70%		2020-01-16		
6	УАУТ-ийн их засварын зураг төсөл					2020-10-02	
Хоёр: ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ							
1	Цагдан хорих байрны зураг төсөл			0%	2020-10-02		

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ (Зураг төсөл боловсруулах ажил)

БҮЛЭГ 4. ЦАР ТАХЛЫН НӨЛӨӨГӨӨР ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.

Г.1 Сумдын ИТХ, ЗДТГ-аас хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Сумдад орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хийгдэж буй ажилд Жаргалтхаан, Баян-Адарга, Дадал, Баян-Овоо сумдын ЗДТГ-аас дотоод хяналтыг хэрэгжүүлсэн бол бусад сумдад энэ талаар хийсэн ажлын баримт аудитад хамрагдсангүй.

Харин Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 9.4⁹-т заасан Галшар, Баянхутаг, Дархан, Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Норовлин, Баян-Овоо, Бор-Өндөр сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй комисс тухайн сумдад хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд 2020 онд хяналт шалгалт хийсэн байна.

Гэхдээ тус ажлын хэсгүүд төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр нь үзэж танилцуулга гаргахаас хэтэрдэггүй, журмаар заагдсан ажлуудыг нарийвчлан бүгдийг үзэж шалгахгүй байх дутагдал байна.

Мөн аудитыг цахимаар хийхэд хүргүүлсэн цахим мэйлийг нээж хардаггүй, сумдын ЗДТГ-ын ажилтнууд баримт, материалыг цахимд бүрэн оруулаагүйгээс материалыг хугацаанд нь ирүүлдэггүй, ирүүлсэн материалын иж бүрдэл дутуу байх зөрчлүүд их гарч байна.

Харин Баянмөнх, Жаргалтхаан, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Батноров, Мөрөн, Хэрлэн сумд, Өлзийт, ХБУлаан тосгон болон аймгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажилд хяналт шалгалт хийсэн талаар аудитад хамруулсангүй.

Аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан болон хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажилд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн хяналтыг Баян-Овоо сум, Өлзийт тосгонд зохион байгуулсан баримт аудитад хамрагдсан бол бусад сум, тосгодод энэ талаар хийгдсэн ажил байхгүй байна.

Г.2 Цар тахлын нөхцөл байдлаас хамаарч сумдад хяналт шалгалтын ажил хийгдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн ажилд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба болон аймгийн МХГ нь Ковид-19 цар тахлын улмаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн өмчид бүртгэсэн талаар аудитад баримт хамрагдсангүй.

Г.3 Хөрөнгө оруулалтын тайланг гаргаж хэлэлцүүлээгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт хийж, Засаг даргын шийдвэрийн хамт тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж байх Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 9.2¹⁰-т зааснаар хөрөнгө оруулалтын дүгнэлт, тайланг гаргаж сумын ИТХ-аар Баянмөнх, Дархан, Өмнөдэлгэр, Биндэр, Норовлин, Батноров сумд хэлэлцүүлсэн байна

⁹ 9.4 “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэл, тайлагналд, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэдсум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороод, иргэний нийгмийн байгууллагуудхяналт тавина.

¹⁰ 9.2 “Сум, дүүргийн ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжисж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 сарын 01-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлнэ..

Үүнээс Баянмөнх, Батноров сумд хөрөнгө оруулалтын ажлыг "Сайн" үнэлсэн шийдвэр гаргасан бол бусад сумдын ИТХ ямар нэг шийдвэр гаргаагүй байна.

Бусад сумд болон аймгийн ИТХ-аар хөрөнгө оруулалтын тайланг хэлэлцүүлсэн талаар аудитад хамрагдсангүй.

Гэвч Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн журам”-ын 9.8¹¹-т заасны дагуу дээрхи 6 сумаас бусад сумын болон аймгийн ИТХ-аар дүгнэлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэлэлцүүлсэн талаар ямар нэг баримт байхгүй байгаа нь тус журмын хэрэгжилт сумдад хангалтгүй байна гэж үзэхээр байна.

Г.4 Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх ажил сумдад хийгдсэн байна.

Хэнтий аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд бий болсон өмчийг хуульд заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэх ажлыг сумдын төсөвт байгууллагууд зохион байгуулсан байна.

Өнгөрсөн онд нийтдээ 112 төсөл, арга хэмжээний дүнд бий болсон 2443.1 сая төгрөгийн хөрөнгийг 16 сум, 4 тосгоны төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид бүртгэж авсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-аар хийгдсэн ажил, Галшар, Дэлгэрхаан сумдын ОНХС-аар 2020 онд хийгдсэн ажлыг орон нутгийн өмчид бүртгэсэн талаар баримт аудитад хамрагдсангүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалтай байдал, санхүүжилт хийгдээгүйгээс нийтдээ 506.8 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээ 2020 онд хэрэгжээгүй байна.

Мөн 473.8 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ хийгдэж дуусаагүй, актаар хүлээлгэн өгөөгүй, орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй зэрэг шалтгааны улмаас орон нутгийн өмчид бүртгээгүй байна. (Орон нутгийн өмчид бүртгээгүй хөрөнгө оруулалтын жагсаалтыг хавсаргае)

Харин 5712.9 сая төгрөгийн 82 төсөл, арга хэмжээний хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэсэн эсэх талаар аудитад баримт хамрагдсангүй.

¹¹ 9.8 “Энэ журмын 9.4, 9.3-т заасан байгууллага дангаараа болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмж, акт, албан шаардлагыг тухайн шатны ИТХ-аар жил бүр хэлэлцүүлнэ.

Холбогдох байгууллагын санал:



2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 520 дугаартай албан бичигт дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

- Орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас 2020 онд хэрэгжүүлсэн төслийн баримт бичгийн эх хувь болон хуулбар хувийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт актаар хүлээлгэн өгсөн.
- Сумдад эрх шилжүүлсэн ажлын хувьд төслийн баримт бичгийг сумын холбогдох албан тушаалтан хариуцаж байна.
- Мөн бага төвөгшилтэй болон технологийн хувьд энгийн ажлыг магадлалаар оруулахгүй байж болох холбогдох дүрмийн хүрээнд ажилласан болно.
- Сумдад хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан ажилтныг 2021 оны 3 дугаар улиралд багтаан томилох чиглэлийг хүргүүлсэн.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231071783

Саналд өгсөн тайлбар:

Аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулсангүй.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө аймаг, сумын дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулахгүй байна.
- Хөрөнгө оруулалт, их засварын ажлын техникийн нөхцөл бүрдүүлэх, газрын зөвшөөрөл авч хэрэгжүүлэх шаардлага хэрэгжихгүй байна.
- Аудитыг цахимаар хийж буйтай холбоотой баримтыг цахимаар ирүүлэх ажил хангалтгүй байна.
- Орон нутгийн төсөв, ОНХС-аас санхүүжих төсөл, арга хэмжээний бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажлыг бүрэн цахимд оруулж чадаагүй байна.
- Тендер зарлахдаа баталгаажаагүй тендерийн баримт бичиг, зураг төсөл, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт цахим системд нийтлэгдсэн байна.
- Зохион байгуулагдсан тендерийн үр дүнг бүрэн ил тод мэдээлээгүй байна.
- Барилга байгууламж барих, их засварын ажлын гүйцэтгэлийг сумдын ЗДТГ бүрэн баталгаажуулаагүй байна.
- Ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх гэрээний биелэлтийг сумдын ЗДТГ дүгнэхгүй байна.
- Зөвлөх үйлчилгээ (Зураг төсөл боловсруулах) авах ажилд шаардлагатай архитектур төлөвлөлтийн болон зураг төслийн даалгавар, загвар зураг батлагдсаны дараа төлөвлөхгүй байна.
- Захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналт хийх гэрээг байгуулж, дүгнэх ажил хангалтай зохион байгуулагдаж чадаагүй байна.
- Сумдад хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж байхгүй байна.
- Сумдын ЗДТГ-т хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний цахим сан бүрдүүлэх ажил хангалтгүй байна.
- Цар тахлаас шалтгаалан хөрөнгө оруулалтад тавигдах хяналт шалгалт, хийгдээгүй байна.
- Хөрөнгө оруулалтын тайлан, дүгнэлт гаргаж ИТХ-аар хэлэлцүүлэх ажил хийгдэхгүй байна.
- Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх ажилд тавих хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Г.Хэрлэнчулуун-д:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтын тайлан дүгнэлт, аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байх,
- Сумдад хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сумын ИТХ болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулсан хяналт шалгалтын ажлыг хийж, хөрөнгө оруулалтын тайланг тухайн шатны ИТХ-аар хэлэлцдэг болгох,

Аймгийн Засаг дарга Ц.Идэрбат-д:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө аймаг, сумын дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж байх,
- Хөрөнгө оруулалт, их засварын ажлын техникийн нөхцөл, газрын зөвшөөрөлтэй хэрэгжүүлэх шаардлагыг мөрдөж ажиллах,
- Сумын ЗДТГ-ын бүтцэд хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтны ажлын байрны тодорхойлолтыг тодорхой болгох,
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг хуульд заасан хугацаанд байгуулж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах,
- Дотоод хяналт, үнэлгээ шинжлэгээний нэгж нь хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөл, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон бусад шаардлагатай тендерийн баримт бичгийн иж бүрдлийг жил бүрийн 1-р сард хянаж, гарсан зөрчлийг нэн даруй засуулах арга хэмжээг авах,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний цахим сан бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх,
- Хөрөнгө оруулалтын тайлан, дүгнэлтийг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлэх ажлыг тогтмолжуулах.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Э.Мөнх-Эрдэнэ-д:

- Зөвлөх үйлчилгээний (зураг төсөл боловсруулах) ажлыг төлөвлөхдөө архитектур төлөвлөлтийн болон зураг төслийн даалгавар, загвар зургийг бэлэн болгосны дараа хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулах,
- Зураг төсөл боловсруулж дуусах хугацааг гэрээнд тусгаж байх,
- ХАА зарлагдсан хөрөнгө оруулалтын ажилд тавих захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтын гэрээг ажил гүйцэтгэх календарьчилсан төлөвлөгөөтэй уялдуулан байгуулж, хэрэгжилтийг үе шат бүр дээр дүгнүүлж байх.
- Сумдад хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын бүх шатны үйл ажиллагаанд газар дээр нь биечлэн зөвлөн туслах ажлыг байнга хэрэгжүүлж, илэрч буй алдаа, дутагдал, зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч байх

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



2021 оны 01 дугаар сарын 09

Дугаар А/11

Чингис хот

Гүйцэтгэлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан "Нийслэл, аймаг дахь Төрийн аудитын газруудын 2021 онд гүйцэтгэх аудитын сэдэв"-ийг үндэслэн, Монгол улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын санаачилгаар хийгдэж буй "Орон нутгийн төсөв болон ОНХС-аас 2020 онд санхүүжсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, зарцуулалт, үр дүн, үр ашиг"-т хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын тайлангаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг audit.mn сайтад бүрэн эхээр нь байршуулан, Үндэсний аудитын газарт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

ХАА-ны цахим системд бүртгэгдээгүй төсөл, арга хэмжээнүүд

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төг/	Төсөв захирагч
		Эхлэх	Дуусах		
	НИЙТ ДҮН	23	23	232.204	23
	Орон нутгийн хөгжлийн сан	15	15	145.404	15
1	Залуучуудын фитнес төв байгуулах	2020	2020	14.628	Баян-Адлага
2	Хаягжуулалт, тэмдэгжүүлэлт	2019	2020	8.500	Биндэр
3	1-р багийн мал угаалгын ванн, хашаа	2019	2020	2.188	Биндэр
4	2-р багийн мал угаалгын ванн, хашаа	2019	2020	2.188	Биндэр
5	4-р багийн мал угаалгын ванн, хашаа	2019	2020	2.188	Биндэр
6	3-р багийн тохижилт	2019	2020	4.000	Биндэр
7	Авто зогсоол	2020	2020	8.000	Биндэр
8	СДЭ-ийн гадна тохижилт	2020	2020	6.500	Биндэр
9	Наадмын талбайн засвар	2020	2020	3.500	Биндэр
10	Ковш худалдан авах	2020	2020	49.843	Галшар
11	50 кВт-ын дизель станц	2020	2020	10.000	Хурх
12	Трансформатор КТП250	2020	2020	10.000	Хурх
13	КТП250-ын хайрцаг, шон кабель	2020	2020	10.000	Хурх
14	ЗАА-ы дулааны шугамын засвар	2020	2020	10.000	Хурх
15	ЕБС-ын цахилгаан монтажны засвар	2020	2020	3.871	Хурх
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	8	8	86.800	8
1	Бархын голын гүүрний харуулын байшин	2020	2020	3.300	Батширээт
2	Хог түрэх ковш	2020	2020	60.000	Батширээт
3	СЗДТГ-т агуулахын барилга худалдан авах	2020	2020	4.500	Жаргалтхаан
4	Гамшигаас хамгаалах эрэн хайх, аврах бүлгийн байрны засвар	2020	2020	3.000	Жаргалтхаан
5	Өлзийт ЕБС	2020	2020	2.500	Хэрлэн
6	Өрхийн ЭМТ (тоног төхөөрөмж)	2020	2020	8.000	Хэрлэн
7	1-р цэцэрлэг (тоног төхөөрөмж)	2020	2020	2.500	Хэрлэн
8	10-р цэцэрлэг (хүүхдийн тоглоом)	2020	2020	3.000	Хэрлэн

Хавсралт 2

Цахим тендерт урилга нийтлэгдээгүй төсөл, арга хэмжээ

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг /сая.төг/	Төсөв захирагч
		Хэлхэс	Дуусах		
	НИЙТ ДҮН	23	23	436.0	23
	Орон нутгийн хөгжлийн сан	19	19	296.6	19
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	4	4	139.4	4
Нэг: Орон нутгийн хөгжлийн сан					
1	Хүндэтгэлийн гэр	2020	2020	11.0	Баянмөнх
2	Худаг гаргаж, байр барих	2019	2020	18.0	Баян-Овоо
3	Гудамж талбайн дүрс ажиглалтын хяналтын систем суурилуулах, сүлжээний угсралт	2019	2020	30.1	Баян-Овоо
4	Сумын төвийн камержуулалт	2020	2020	20.0	Баянхутаг
5	Хог цэвэрлэгч машин (эксаватор)	2020	2020	40.0	Баянхутаг
6	Сайжруулсан замын их засвар, тохижилт	2020	2020	24.7	Баянхутаг
7	Багт мал тарилгын хашаа, угаалгын ванн	2020	2020	5.0	Биндэр
8	Багуудад гүний худаг	2020	2020	6.8	Биндэр
9	Сургуулийн спорт заалны засвар	2020	2020	35.0	Дархан
10	Худаг, мал угаалгын ванн барих	2020	2020	18.3	Дархан
11	Гэрэлтүүлэгийн урсгал засвар	2020	2020	7.5	Норовлин
12	Ангирт багийн төвийн гүн өрмийн худаг	2020	2020	8.0	Норовлин
13	Онон багийн гадна тохижилт	2020	2020	9.0	Норовлин
14	Хогийн цэг тохижуулах	2020	2020	10.0	Өмнөдэлгэр
15	Сумын төвийг камержуулах	2020	2020	10.0	Өмнөдэлгэр
16	Сумын төвийн гэрэлтүүлэгийг сайжруулах (нэмэгдүүлэх)	2020	2020	10.0	Өмнөдэлгэр
17	Гүн өрмийн худаг гаргах (Хондот, Жаргалант)	2020	2020	13.8	Цэнхэрмандал
18	Бог мал угаах ванн барих (Овоот)	2020	2020	4.5	Цэнхэрмандал
19	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байрны зураг төсөл	2020	2020	15.0	Аймаг
Хоёр: ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ					
1	Усны машин	2020	2020	27.0	Өмнөдэлгэр
2	Норовлин сумын ЭМТ-ийн барилгын үргэлжлэл	2020	2020	39.0	Аймаг
3	Дизель генератор, дулаан хязгаарлагч	2020	2020	14.4	Аймаг
4	1-р багийн халаалтын уурын зуух, тоноглол	2020	2020	59.0	Аймаг

Хавсралт 3

ХАА-ны үр дүнг мэдээлээгүй ажлууд

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	Төсөв захирагч	Шалгаруулалтын код	Оролцогч	Шалгарсан оролцогч
	НИЙТ ДҮН	446.8	19	19	6	19
	Орон нутгийн хөгжлийн сан	359.1	15	15	5	15
1	Хотын төв замын дагуух хашаа хайс болон гэрэлт самбаруудыг шинэчлэх	23.6	Бэрх	ХЭАБЭСЗДТГ/202009024	1	Илгээгдсэн
2	Мал эмнэлгийн жижиг лабораторитой болох	22.1	Батширээт	ХЭАБШСЗДТГ/202012005	1	Илгээгдсэн
3	Гудамжны гэрэлтүүлэг шинээр тавих	23.8	Батширээт	ХЭАБШСЗДТГ/202012006	3	Илгээгдсэн
4	Гудамжны хяналтын камер	22.4	Баян-Адрага	ХЭАБАСЗДТГ/202001027		Нийтлэг дээгүй
5	Хогны машин	21.9	Баянмөнх	ХЭАБМСЗДТГ/202001002		Нийтлэг дээгүй
6	Гэр бүлийн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	10.4	Баян-Овоо	ХЭАБОСЗДТГ/202012017		Нийтлэг дээгүй
7	Цэцэрлэгийн гадна талбайн тохижилт	10.0	Биндэр	ХЭАБИСЗДТГ/202001010		Нийтлэг дээгүй
8	Сургуулийн гадна тохижилт	10.0	Биндэр	ХЭАБИСЗДТГ/202001012		Нийтлэг дээгүй
9	ЭМТ-ийн барилгын урсгал засвар	32.0	ХБУ	ХЭАХБУСЗДТГ/202004009		Нийтлэг дээгүй
10	Гүн өрмийн худаг шинээр гаргах (2019)	24.0	Жаргалт хаан	ХЭАЖХСЗДТГ/201901010	0	Нийтлэг дээгүй
11	Гэрэлтүүдгийн тоног төхөөрөмж нэмэгдүүлэх	18.6	Жаргалт хаан	ХЭАЖХСЗДТГ/202001009	1	Илгээгдсэн
12	Ахмадын байр, Баянзүрх, Хэнтий багийн соёлын төвийн урсгал засвар	13.4	Өмнөдэлгэр	ХЭАӨДСЗДТГ/202001003		Нийтлэг дээгүй
13	Биеийн тамирын талбайн тоглоомын тохижилт	39.9	Цэнхэр мандал	ХЭАЦМСЗДТГ/202012015		Нийтлэг дээгүй
14	6-р цэцэрлэгийн баруун талыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, аюулгүйн бүс бий болгох	52.0	Хэрлэн	ХЭАХЭСЗДТГ/202001012		Нийтлэг дээгүй
15	Нийтийн халуун ус	35.0	Хэрлэн	ХЭАХЭСЗДТГ/202001010		Нийтлэг дээгүй
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	87.7	4	4	1	4
1	С78, А24, А27 байранд тус тус гэрэлтүүлэг бичвэр хийх	22.2	Хэрлэн	ХЭАХЭСЗДТГ/202001013		Нийтлэг дээгүй
2	Аврах бүлгийн байрны засвар (Жаргалтхаан)	19.0	Аймаг	ХЭАОНӨГ/202009067		Нийтлэг дээгүй
3	Баянмөнх сумын "Залуус төгөл"-ийн хашаажуулалт	16.5	Аймаг	ХЭАОНӨГ/202009071		Нийтлэг дээгүй
4	Зуухын Баянголын модон гүүр шинээр байгуулах (Батширээт)	30.0	Аймаг	ХЭАОНӨГ/202012062	1	Илгээгдсэн

Хавсралт 4

Захиалагчийн хяналтын баримтгүй төсөл, арга хэмжээнүүд

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих		Гэрээ байгуулсан	Ажил гүйцэтгэх хугацаа	
		Төсөв захирагч	Сум	Гүйцэтгэгч	Эхлэх огноо	Дуусах огноо
	НИЙТ ДҮН	14	14	14	14	14
	Орон нутгийн хөгжлийн сан	11	11	11	11	11
1	Хотын төв замын дагуух хашаа хайс болон гэрэлт самбаруудыг шинэчлэх	Бэрх	Бэрх	"Өндөрхаан өргөө" ХХК	2020-10-08	2020-10-30
2	6-р цэцэрлэгийн баруун талыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, аюулгүйн бүс бий болгох (багц 2)	Хэрлэн	Хэрлэн	"Аглаг ой" ХХК	2020-09-14	2020-10-15
3	Гүрмийн нуурын хашаажуулалтын үргэлжлэл	Аймаг	Баян-Овоо	"Нүнжигтхан хэнтий" ХХК	2020-06-25	2020-08-25
4	Хэрлэн сумын багуудын гэр хороололд жишиг гудамж бий болгох (багц 3)	Аймаг	Хэрлэн	"Буян-Уул"	2020-09-03	2020-09-30
5	Халуун усны барилга /Хэрлэн /	Аймаг	Хэрлэн	"Юу Эн Ти Эс" ХХК	2020-08-15	2020-10-30
6	Хүүхдийн тоглоомын талбай байгуулах, тохижилт /Хэрлэн/ (багц 2)	Аймаг	Хэрлэн	"Авид хайрхан" ХХК	2020-09-24	2020-10-24
7	Ундны усны худаг байгуулах /Хэрлэн сумын багууд/	Аймаг	Хэрлэн	"Буян-Уул" ХХК	2020-08-01	2020-09-01
8	Хэнтий Ус ХХК-ний уурын зуухны өргөтгөл	Аймаг	Хэрлэн	"Өндөрхаан өргөө" ХХК	2020-06-02	2020-07-10
9	Усан оргилууруудын засвар /Хэрлэн/	Аймаг	Хэрлэн	"ЭНРЭН" ХХК	2020-06-09	2020-07-07
10	Орон сууцын байруудын орц, дээвэр, фасадны засвар /Хэрлэн/	Аймаг	Хэрлэн	"Эс Жи Эм" ХХК	2020-05-11	2020-06-11
11	Хуучин сургуулийн барилгыг засварлаж хүүхэд хөгжлийн төв, ахуйн үйлчилгээний төв байгуулах /Цэнхэрмандал/	Аймаг	Цэнхэр мандал	"Юу Эн Ти Эс" ХХК	2020-06-08	2020-08-08
	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	3	3	3	3	3
1	Аврах бүлгийн байрны засвар (Баян-Адрага)	Аймаг	Баян-Адрага	"ТЭДҮ" ХХК	2020-12-02	2020-12-16
2	Норовлин сумын ЭМТ-ийн барилгын үргэлжлэл	Аймаг	Норовлин	"Хос ховор сувд" ХХК	2020-09-21	2020-10-20
3	Зуухын Баянголын модон гүүр шинээр байгуулах (Батширээт)	Аймаг	Батширээт	"Хушин Эрдэн" ХХК	2020-10-01	2020-11-01

Хавсралт 5

Орон нутгийн өмчид бүртгээгүй төсөл, арга хэмжээнүүд

/сая.төг/

д/д	ТАХ-ны нэр	Сум	Санхүүжих эх үүсвэр	Батлагдсан төсөв	2020 онд санхүүжих	Тайлбар
	3	А	2	4	5	
1	Сумын төвийн камержуулалт	Баянхутаг	ОНХС	20.0	20.0	Бүртгэлд аваагүй
2	Сайжруулсан замын их засвар, тохижилт	Баянхутаг	ОНХС	24.7	24.7	Бүртгэлд авах боломжгүй
3	Багт мал тарилгын хашаа, угаалгын банн	Биндэр	ОНХС	5.0	5.0	Актаар хүлээлгэн өгөөгүй
4	Багт гүний худаг	Биндэр	ОНХС	6.8	6.8	Актаар хүлээлгэн өгөөгүй
5	Наадмын талбайн тохижилт	Биндэр	ОНХС	3.5	3.5	Дутуу хийгдсэн тул хүлээж аваагүй
6	Цог-Өндөр багийн хогийн цэгийг дарж булах	Хэрлэн	ОНХО	9.0	9.0	Бүртгэлд авах боломжгүй
7	Цогт-Өндөр багийн айл өрхийн хаягжилт	Хэрлэн	ОНХС	3.3	3.3	Бүртгэлд авах боломжгүй
8	Баамын байрны дээврийн их засвар /1-р баг/	Хэрлэн	ОНХС	9.0	9.0	Бүртгэлд авах боломжгүй
9	5 найман айлын фасад	Хэрлэн	ОНХС	84.0	84.0	Бүртгэлд авах боломжгүй
10	Уурхайчин цэцэрлэгт хүрээлэнгийн тохижуулалтын ажил	Бор-Өндөр	ОНХС	100.0	100.0	хийгдэж дуусаагүй тул бүртгээгүй
11	Хөл бөмбөгийн талбай	Бор-Өндөр	ОНХС	100.0	100.0	хийгдэж дуусаагүй тул бүртгээгүй
12	Дунд сургуулиас гэр хороолол явах явган зам янзлах	Бор-Өндөр	ОНХС	40.2	40.2	хийгдэж дуусаагүй тул бүртгээгүй
13	Хөдөө хэсэгт мал угаалгын ваннтай болох	Бэрх	ОНХС	4.5	4.5	"Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн хүрээнд мал угаалгын ванн COVID-19 холбоотойгоор ХХААГазарт бичиг баримтаа хүлээлгэн өгөөгүй байгаа.
14	ЕБС-ын цахилгаан монтажны засвар	Гурванбаян	ОНХС	3.9	3.9	Актаар хүлээлгэн өгөөгүй
15	Өмнөдэлгэр сумын Хэнтий, Талын булаг багт гүн өрмийн худаг гаргах	Аймгийн ЗДТГ	ОНХО	30.0	30.0	хийгдэж дуусаагүй тул бүртгээгүй
16	Хот тохижилтын тоног төхөөрөмж /Бо-Өндөр сум/	Аймгийн ЗДТГ	ОНХО	30.0	30.0	хийгдэж дуусаагүй тул бүртгээгүй
	16	ДҮН		473.8	473.8	